


Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2023 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн  
12/01 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралт



**УЛААНБААТАР ХОТООС ОРОН НУТАГТ ШИЛЖИН ИРЖ БУИ  
ИРГЭД АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫГ ДЭМЖИХ  
“НЭЭЛТТЭЙ УВС АЙМАГ” ХӨТӨЛБӨР**

2023 оны 01 сарын 15-ний өдөр

Увс аймаг

**Нэг. Нийтлэг үндэслэл**

Монгол Улсын Засгийн газар “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлого, “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг УИХ-аар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тус бодлогын баримт бичигт боомт, эрчим хүч, аж үйлдвэржилт, хот хөдөөгийн тэнцвэрт хөгжил, ногоон хөгжил, төрийн бүтээмж зэрэг 6 багц асуудал туссан.

Засгийн газрын 2022 оны 350 дугаар тогтоолоор “Хот хөдөөгийн хөгжлийн тэнцвэрийг хангах, төвлөрлийг сааруулах, авто замын түгжрэлийг бууруулах, үндэсний хороо байгуулан ажиллаж байна.

Хот хөдөөгийн тэнцвэрт хөгжлийг хангах зорилтын хүрээнд орон нутгийг хөгжүүлэх, Улаанбаатар хотоос орон нутагт шилжин суурьших иргэдийн ажиллаж, амьдрах нөхцөл боломжийг нэмэгдүүлэх, орон нутагт үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгж, байгууллагуудыг дэмжих зорилгоор “Хот, хөдөөгийн сэргэлтийн бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар авах арга хэмжээний тухай” Засгийн газрын 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 419 дүгээр тогтоол, Засгийн газрын хуралдааны 56 дугаар тэмдэглэл гарсан.

Дээрх шийдвэрүүдийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны 157-р захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн 2022-2024 онд хэрэгжүүлэх ажлын ерөнхий төлөвлөгөөгөөр салбарын яам, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжүүдийн авч хэрэгжүүлэх ажлын чиглэлүүдийг баталсан.

Нутгийн удирдлагын байгууллага, бүх шатны хурлын Төлөөлөгчид, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын санаачилга, оролцоотойгоор “Алсын хараа-2050 урт хугацааны бодлого”, “Шинэ сэргэлт”-ийн бодлогын үзэл баримтлалд нийцүүлэн аймаг, орон нутгийн онцлогийг тусгасан бие даасан хөтөлбөр батлан, хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлага гарч байна.

Иймд аймаг орон нутгийн өнөөгийн нөхцөл байдал, нийгэм, эдийн засаг, техник, технологи, үндэсний үйлдвэрлэлийн ололт амжилт, нөөц боломж, түүх,

соёл, зан заншил, уламжлал, оюун санааны үнэт зүйлсийг шилжин ирэх иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, олон нийтэд мэдээлэн сурталчлах “НЭЭЛТТЭЙ УВС АЙМАГ” хөтөлбөр (цаашид “хөтөлбөр” гэх)-ийг холбогдох бодлогын баримт бичиг, хөтөлбөр, судалгаанд үндэслэн боловсруулсан болно.

### **Хоёр. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд баримтлах зарчим**

2.1. “НЭЭЛТТЭЙ УВС АЙМАГ” хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална.

2.1.1. Монгол Улсын хууль, хөгжлийн бодлогын баримт бичиг, холбогдох үндэсний хөтөлбөрүүд, аймаг орон нутгийн бодит нөөц бололцоо, бүс нутгийн эдийн засгийг кластержуулан хөгжүүлэх, орон нутаг өөрийгөө бие даан санхүүжүүлэх эдийн засгийн бодлогод тулгуурлах;

2.1.2. Хөтөлбөрийн агуулгад аймаг орон нутагт шилжин ирж ажиллаж, амьдрах үйл ажиллагаа эрхлэн явуулахад үүсэх давуу тал болон үүсэж болзошгүй хүндрэл бэрхшээлийг зөв тооцож тусгахыг эрмэлзэн мэдээллийг нээлттэй, тэгш, хүртээмжтэй түгээх.

2.1.3 Хувь хүн, ААН, байгууллагад хуулиар олгогдсон эрхийг дээдлэн хүндэтгэсэн, үүрэг хариуцлагыг ухамсарлуулан таниулж хандлагын өөрчлөлтөд уриалсан

2.1.4 Бизнесийн орчны тэгш боломж, шударга өрсөлдөөнийг эрхэмлэсэн, хөгжил дэвшил, бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын таатай орчин, олон талт харилцааны онцлогуудыг уялдуулан тодорхойлсон байх;

2.1.5 Хөтөлбөрийн хэрэгжилтэд иргэд олон нийт, аж ахуйн нэгж, байгууллага, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагууд, бизнесийн болон мэргэжлийн холбоодын оролцоог түлхүү дэмжих.

### **Гурав. Хөтөлбөрийн зорилго**

3.1. Хөтөлбөрийн зорилго нь аймагт шилжин ирж суурьшин ажиллах, амьдрах, үйл ажиллагаа явуулах, иргэд, ААН, байгууллагыг хүлээн авахад шаардагдах бэлтгэлийг хангах, аймгийн хөгжлийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлох, аймаг орон нутгийн талаарх нэгдсэн ойлголт, мэдээллийн нэгдмэл удирдлага, зохицуулалтыг бий болгож цахимжуулах, төрийн үйлчилгээг оновчтой, түргэн шуурхай болгох, хэрэгжилтийг хангах чиглэлээр тодорхой зорилтуудыг дэвшүүлэн хэрэгжүүлэх замаар аймаг, сум орон нутгаа хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

### **Дөрөв. Хөтөлбөрийн зорилт**



4.1 Аймгийн онцлог, түүх, соёлын нөөц боломж, хөдөө аж ахуй, аялал жуулчлал, нутгийн брэндээ ард түмэнд таниулах, эдийн засгийн хувьд бие дааж аймаг орон нутгаа хөгжүүлэх;

4.2 Иргэдэд ажиллаж амьдрах, аж ахуйн нэгж байгууллагад үйл ажиллагаа явуулах таатай орчныг бүрдүүлэх.

4.3 Нийгмийн салбарын үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах

4.4 Мэргэжлийн боловсон хүчний хангалтыг сайжруулан чадавхжуулах, тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх.

### **Тав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа**

5.1 Аймгийн онцлог, түүх, соёлын нөөц боломж, хөдөө аж ахуй, аялал жуулчлал, нутгийн брэндээ ард түмэнд таниулах, эдийн засгийн хувьд бие дааж аймаг, орон нутгаа хөгжүүлэх зорилтын хүрээнд:

5.1.1 Улаанбаатар хотоос орон нутагт шилжин ирж ажиллаж амьдрах иргэдэд үзүүлэх дэмжлэг хөнгөлөлтүүдийн талаар мэдээлэл хүргэх ажлыг үе шаттай зохион байгуулах.

5.1.2 Баруун Монголын өв соёл, байгалийн болон түүх соёлын үзэсгэлэнт газруудыг иргэд, жуулчдад сурталчлан таниулах, аялал жуулчлалын нөөц баялагт үндэслэн төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх.

5.1.3 Аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг сайжруулах, сум бүр өөрийн онцлогт тохирсон арга хэмжээг бий болгох, зохион байгуулах.

5.1.4 Аялал жуулчлалын барилга байгууламж, дэд бүтцийг дэмжих, сумдад жуулчдын ая тухыг хангах орчныг бүрдүүлэх.

5.1.5 Аялал жуулчлалын зориулалтаар олгосон газрын ашиглалтыг сайжруулах, шинээр газар олгох;

5.1.6 Дундын хоршоодыг чадавхжуулан хөдөө аж ахуйн бүтээмж үр ашгийг нэмэгдүүлж, байгальд ээлтэй дэвшилтэт технологид суурилсан шинэ ажил үйлчилгээг дэмжин хөгжүүлэх, “Шинэ хөдөө Увс” төслийг үргэлжлүүлэх (Чацарганы үйлдвэрийн тоног төхөөрөмж, Мал төхөөрөх цехийн тоног төхөөрөмж, Зөгийн аж ахуй, Цагаан ултай гутлын кластер, Загвар хоршоод орон нутгийн хөгжлийг дэмжих барилгыг ашиглалтад оруулах, Хадлангийн тоног төхөөрөмж, Арьс шир боловсруулах цех)

5.1.7 Газар тариалангийн эргэлтийн талбайн ашиглалтыг сайжруулж, усалгаатай газар тариалангийн талбайг нэмэгдүүлэх ажлыг дэмжих. (Арсайн услалтын систем)

5.1.8 Бизнес инкубатор төвийг байгуулж гарааны бизнес эрхлэгчдийг чадавхжуулах.

5.1.9 Сумдад ашиг шимт мах, сүүний чиглэлийн үхрийн фермерийн аж ахуйг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх.

5.1.10 Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн мэргэжилтэн бэлтгэх тогтолцоог авто гагнуур, токарь, нийтийн хоол зэрэг чиглэлээс гадна малын бага эмч, эрчимжсэн мал аж ахуй, усжуулалтын мэргэжилтэнг бэлтгэхэд чиглүүлэх

5.1.11 Хил залгаа ОХУ-ын улс, мужуудтай эдийн засаг, нийгмийн хөгжлийг дэмжсэн хамтын ажиллагааг хөгжүүлэх

5.1.12 Байгалийн нөөцийг зүй зохистой ашиглах, эдийн засгийн эргэлтэд оруулах санал санаачлагыг хуулийн хүрээнд оновчтой зохион байгуулах

5.1.13 “Хоёр живаа харгаа” хөтөлбөрийн хүрээнд “Увс аймаг 100 жил” цэцэрлэгт хүрээлэнг байгуулах, ногоон ажлын байрыг бий болгох

**5.2 Иргэдэд ажиллаж амьдрах, аж ахуйн нэгж байгууллагад үйл ажиллагаа явуулах таатай орчныг бүрдүүлэх.**

5.2.1 Төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд орон сууцжуулахад орон нутгаас дэмжлэг үзүүлж, дэд бүтэц, газар олголтыг шийдвэрлэх, иргэдийг ипотекийн 3 хувийн зээлд хамруулах.

5.2.2 Хөгжлийн ирээдүйтэй сууринг төлөвлөн хэрэгжүүлэх. (Олон улсын худалдаа, тээвэр логистикийн төвийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр, Увс агро-Хөх үхэрт дэд бүтцийг орон нутгийн хөрөнгө оруулалтаар, Далан түрүү дэд бүтцийг улсын төсвийн санхүүжилтээр, Баруунтурууны хөдөө аж ахуйн цогцолборын бүтээн байгуулалтыг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хийж, ажлын байр бий болгох);

5.2.3 “Сумын хөгжил- инженерийн дэд бүтэц”-ийн арга хэмжээг хэрэгжүүлэх.

5.2.4 Боомтын сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлэх.

5.2.5 Хөрс, агаарын бохирдлыг бууруулах.

5.2.6 Иргэд, аж ахуйн нэгжийн бизнес эрхлэх боломжийг бүрдүүлсэн газар зохион байгуулалтын төлөвлөлт хийж, ерөнхий төлөвлөгөөг тодотгох

5.2.7 Малын тэжээлийг дотооддоо үйлдвэрлэхэд төрөөс дэмжлэг үзүүлэх

5.2.8 Уул уурхайн үйлдвэрлэлийг дэмжсэн аймгийн бодлого гаргах, Давстын хүдэн, Наранбулагийн төмөр боловсруулах зэрэг үйлдвэрийг байгуулах

5.2.9 Засгийн газрын таван жилийн үндсэн чиглэл, дөрвөн жилийн үйл ажиллагааны хөтөлбөр дэх Ховд, Увсыг холбосон 163.3 км авто зам, Дэглий цагаан нисэх буудлын өргөтгөл хийх, статусыг олон улсын болгох



5.2.11 Сумын хөгжлийн төлөвлөгөөнд бизнес эрхлэх орчныг хөгжүүлэх төсөл боловсруулах

### **5.3 Нийгмийн салбарын үйлчилгээний чанар**

#### **хүртээмжийг сайжруулах хүрээнд;**

5.3.1 Шилжин ирсэн иргэн аж ахуй нэгж байгууллагыг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, ЖДҮ хөгжүүлэх сан, хоршоо хөгжүүлэх сан, олон улсын төсөл хөтөлбөр, хөнгөлөлттэй зээлд хамруулах.

5.3.2 Орон нутагт шилжин ирж, бизнесээ эхлүүлэн шинээр үл хөдлөх хөрөнгө бий болгосон, ажлын байр нэмэгдүүлсэн аж ахуй нэгж, иргэдэд эхний 3 жилд татварын 90 хувиар хөнгөлөх, жилийн 1 хувийн хөнгөлөлттэй хүүтэй банкны зээлд хамруулах зэргээр дэмжлэг үзүүлэх

5.3.3 Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагуудтай хамтын ажиллагааг идэвхжүүлж аймагтаа ажлын байр нэмэгдүүлэх;

5.3.4 Ерөнхий боловсролын сургуулиудын хэв шинжийг тодорхойлон, бүсийн ахлах сургуулиудыг дэмжиж ажиллах.

5.3.5 Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн сургалтын тэргүүлэх чиглэлийг тодорхойлон сургалтын хөтөлбөрийг шинэчилж, шаардлагатай мэргэжилтэнг шаталсан болон 2+2 хөтөлбөрөөр бэлтгэж, сургалтын дадлагын бааз, газрыг шинэчлэн зохион байгуулах.

5.3.6 Эрүүл мэндийн төв, Баруунтуруун, Өндөрхангай, Өмнөговь сумын сум дундын эмнэлэгийн оношлогооны чадавхыг сайжруулж, зайн оношилгооны тоног төхөөрөмжөөр хангах, эмчилгээний хүртээмжийг сайжруулах.

5.3.7 Аймгийн нэгдсэн эмнэлэг болон хувийн хэвшлийн эмнэлгээс үзүүлэх нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээг нэмэгдүүлэх,

5.3.8 Соёлын бүтээлч үйлдвэрлэл, соёлын биет болон биет бус өвийг тээгчийг дэмжих.

5.3.9 Ойрад хөгжимт жүжгийн театрын барилгыг ашиглалтад хүлээн авч, үзвэр үйлчилгээний таатай орчин нөхцөлийг бүрдүүлэх;

5.3.10 Эмч, багш нарыг орон нутагт ажиллахад нь сумдын нутгийн удирдлагын дэмжлэгийг бий болгож, ажиллах орчин нөхцөлийг сайжруулан хамтран ажиллах

#### **5.4 Мэргэжлийн боловсон хүчний хангалтыг сайжруулан чадавхжуулах,**

##### **тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх зорилтын хүрээнд;**

5.4.1 Хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй ажлын байрны хангалтыг сайжруулах, дэмжлэг үзүүлэх (боловсрол, эрүүл мэнд, соёл урлаг, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтэц, барилга, аялал жуулчлал, мал аж ахуй, газар тариалангийн салбарт)

## **Зургаа. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт**

6.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг аймгийн хэмжээнд удирдан зохион байгуулах үүрэг бүхий дэд ажлын хэсэг (цаашид “ажлын хэсэг” гэх) ажиллана. Ажлын хэсгийн ахлагч нь Монгол Улсын ерөнхий сайдын 157 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн гишүүн, аймгийн Засаг даргын орлогч байна.

6.2. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг аймгийн Засаг дарга батална. Ажлын хэсэг нь 9 хүртэл гишүүнтэй байх бөгөөд (хамтын ажиллагаа, боловсрол, эрүүл мэнд, хөдөө аж ахуй, аялал жуулчлал, газрын харилцаа, хэвлэл мэдээллийн болон санхүү, төсөв, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн гэх мэт) ажилтны төлөөлөлтэй байна. Түүнчлэн УБ хот дахь нутгийн зөвлөл, бизнесийн байгууллага, иргэний нийгмийн байгууллага, мэргэжлийн холбоод, эрдэмтэн судлаачдын төлөөллийг зөвшилцлөөр оруулж болно.

6.3. Ажлын хэсэг аймгийн хэмжээнд хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж аймгийн ИТХ-аар батлуулна.

6.4. Аймгаас мэдээллээ нээлттэй түгээх зорилгоор Улаанбаатар хот болон бүс нутгийн түвшинд зохион байгуулагдах үзэсгэлэн худалдаа, форум, хурал зөвлөгөөн, спорт, соёл урлагийн арга хэмжээнд оролцож аймгаа сурталчлах асуудлыг Ажлын хэсгийн ахлагч шийдвэрлэх ба шаардлагатай тохиолдолд аймгийн Засаг даргатай зөвшилцөн Засаг даргын удирдлагын зөвлөлийн хурал болон ИТХ-ын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлнэ.

6.5. Дэд ажлын хэсэг олон нийтэд мэдээлэл хүргэх, сурталчилах, үйл ажиллагааг Засгийн газрын дэргэдэх Ажлын хэсэгтэй хамтран нэгдсэн журмаар зохион байгуулах бөгөөд аймгийн хэмжээнд шинээр буй болсон ажлын байр, тухайн салбарт дутагдаж буй шаардлагатай боловсон хүчний судалгаа, шилжилт хөдөлгөөний бүртгэл зэрэг аймгийн нээлттэй мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлсэн байна. Улмаар төв мэдээллийн сантай мэдээлэл солилцох ажлыг орон нутаг дахь бүртгэл хариуцсан ажилтан шуурхай зохион байгуулна.

6.6. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад ажлын хэсгээс тогтмол хяналт тавьж, хагас болон бүтэн жилээр хэрэгжилтийг дүгнэн хэлэлцэж, аймгийн Засаг дарга, ИТХ, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт тайлагнана.

### **Долоо. Хэрэгжүүлэх хугацаа**

7.1. Хөтөлбөрийн эхний шатыг 2023-2024 оны 1 дүгээр улирал дуустал нийт 15 сарын хугацаанд хэрэгжүүлнэ.



### **Найм. Хөтөлбөр хэрэгжүүлэх хөрөнгийн эх үүсвэр**

8.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг дараах эх үүсвэрээр бүрдүүлнэ:

8.1.1. Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө;

8.1.2. Хөгжлийн хөтөлбөрүүд, олон улсын байгууллагын тусламжийн хөрөнгө;

8.1.3. Хувийн хэвшлийн хандив, тусламжийн хөрөнгө;

8.1.4. Бусад.

8.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний дагуу тухайн жилийн үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийг жил бүрийн аймгийн төсөвт тусган санхүүжүүлнэ.

### **Ес. Хөтөлбөрийн хэрэгжилтийн шалгуур үзүүлэлт**

9.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг дараах шалгуур үзүүлэлтээр дүгнэнэ:

9.1.1. Аймагт шилжин ирсэн иргэдийн бодит тоон өсөлт 10%-иас дээш нэмэгдсэн эсэх;

9.1.2. Үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ, бүтээн байгуулалт, аялал жуулчлал гэх мэт бүх төрлийн үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгжийн тоо;

9.1.3. Аймаг орон нутагт шинээр бий болсон ажлын байрны тоо;

9.1.4. Иргэд, ААН байгууллагууд, олон нийт рүү чиглэж тэдгээрийг татах чиглэлээр зохион байгуулсан ажлууд, түүний үр дүн;

9.1.5. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 тоот тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын “Хүн амын нэмэгдэлтийн хувь, төсвийн байгууллага, хуулийн этгээд тэдгээрийн салбар нэгжийн болон албан хаагчийн шилжилтийн хувь” шалгуур үзүүлэлтээр хэрхэн дүгнэгдсэн байдал;

9.2. Ажлын хэсэг хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт бүрээр хүрэх зорилтот үзүүлэлтийг жил бүр тогтооно.

Ажлын хэсэг